



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 231

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гүйцэтгэх захирлын 2014 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 2011 дугаар тушаал, "Дархан брокер ҮЦК" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 12/3 тоот хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Дархан брокер ҮЦК" ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2015 оны 1 дүгээр сарын 5-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийтай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг "Дархан брокер ҮЦК" ХХК /Ж.Очирсүх/-д анхааруулсугай.
3. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагааны газар /М.Энхтуяа/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д. АНГАР